

Эрхэм уншигч олон түмэнд энд толилуулан буй Монгол-Америкийн харилцаа гэдэгт гарчгийг хараад зарим хүн Монгол-Америкийн харилцаа гээд байх юм юу байдаг билээ гэж гайхаж магадгүй. Туулж өнгөрүүлсэн он жилүүдэд манай хоёр орны хооронд улс төр, эдийн засгийн харилцааны анхны эх суурь тавигдсанаас хойш нэлээд олон жил болжээ. Энэ тухай одоогоор бидэнд бэлэн материал хомс тул холбогдох баримтуудыг судлаачид-эрдэмтдийн бичсэн ном, өгүүлэл зэрэгт орсон хэсэг бусаг зүйлүүдийг түүвэрлэн авч, архивын баримт материал зэргийг ашиглав.

### 1. Улс, төр эдийн засгийн талаар

1912 оны 11-р сард Богд гэгээний Засгийн газрын Гадаад явдлын яамнаас тусгаар тогтнолоо тунхаглаж, Богд гэгээнийг хаан ширээнд өргөмжилсөн тухай ноотыг есөн улс, тухайлбал, Англи, Франц, Герман, АНУ, Япон, Дани, Голланд, Бельги, Австрийн засгийн газруудад явуулжээ. Уг ноотоор Богд гэгээний засгийн газар нь дээр дурдсан улсуудын засгийн газруудтай дипломат төлөөлөгчид солилцож, худалдааны гэрээ хэлэлцээр байгуулах санал тавьжээ. Тэрхүү ноотуудыг Харбинд суугаа тэдгээр орны консулуудад Хөлөнбуйрын сайдаар дамжуулан тараан өгчээ.<sup>1</sup>

Хаант Орос, болон Хятадад элчин сайдаар сууж байсан, Америкийн нэртэй дипломат В. Рокхилль гэгч Монголын байдалтай танилцах зорилгоор 1912 оны 12 дугаар сард Хүрээнд иржээ. Тэр үед албан хэргээр Петербургт байсан ерөнхий сайд, Сайн ноён хан Намнансүрэн, Хүрээнд ирүүлсэн цахилгаандаа: «Рокхилль бол Далай ламтай сайн харилцаатай хүн тул хэрэв тэр хүн хүсвэл Богд хаантай уулзуулах хэрэгтэй»<sup>2</sup> гэж захиж байжээ. Рокхилль Монголд хүрэлцэн ирэхэд Хүрээнд байсан Хаант Орос улсын төлөөлөгчид далайн цаадах орны зочин ирсэн явдлыг ихээхэн болгоомжлон үзэж, түүний алхам бүрийг хараанаасаа салгахгүй байлаа. Оросын ерөнхий консул Миллер, Рокхиллийг газар сайгүй дагалдаж явдаг байжээ. Рокхилль ч Монголын эрх баригчидтай харилцахдаа Хаант Оросын консулын орчуулагчийг аргагүй хэрэглэж байжээ. Энэ бүгд Рокхиллиас Богд гэгээний сайдуудтай ярилцсан ярианд нөлөөлсөн нь эргэлзээгүй. Миллер цааш өөрийн мэдээлэлд Рокхиллийн Монголд хүрэлцэн ирсэн учрыг дүгнэж «Рокхилль засгийнхаа газраас өгсөн тусгай даалгаврыг биелүүлэхийн тул ихээхэн жуулчлалыг хийж яваа юм байна гэдэг сэтгэгдлийг надад үлдээв» гэжээ.<sup>3</sup>

Богд хаант Монгол улсын үед АНУ-аас нийслэл Хүрээнд худалдааны ажлыг эрхэлж байсан Ларсенд Богд хааны засгийн газар гүнгийн зэрэг хэргэмээр шагнаж байсан юм.<sup>4</sup> Үүнээс үзэхэд Богд хаан АНУ-ыг ихэд талархаж дэмжлэг туслалцаа авахыг хүсэж байсны зэрэгцээ Америкаас Ларсенаар дамжуулан өөрийнхөө засгийн газрыг дэмжүүлэхийг чармайж байсан зэрэг учир шалтгаан байсан бололтой.

Монгол-Америкийн худалдааны харилцаа ХХ зууны эхээр эхэлжээ. Их хүрээний дэлгүүр хоршоо, зах зээл дээр орос, хятадын бараа таваараас гадна Америк, Францын шампанск, Филиппины янжуур, Япон, Германы гоёл чимэглэлийн зүйлс өргөнөөр худалдагдах болжээ.<sup>5</sup> Мон-

\* А. Дамдинсүрэн — Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

голд капиталист шинж бүхий худалдааны нэлээд олон пүүсүүд бий болжээ. Стукен нарын К<sup>0</sup> гэдэг пүүс 1904 оноос, Бидерман пүүс 1909 оноос, Швецов-1911 оноос, мөн түүнчлэн Яков Зергаген гэх мэт пүүсүүд ажиллаж байлаа. Стукен, Зергагений пүүс тус бүр жилдээ 100000 пүү ноос худалдан авч байжээ. Дээрх пүүсүүдийн олсон түүхий эд, жууч нарын гараар дамжин өнгөрч шууд Герман, Англи, Америк руу тээвэрлэгдэж байв.<sup>6</sup> Хүрээний Баруун Со гүний хүрээнд Хятад дэлгүүр 3, орос дэлгүүр 2 байснаас орос дэлгүүрийн эзэн нь Америкийн Рихардын пүүсэнд ноос худалдан авч байжээ.<sup>7</sup>

1900 оны эхээр америк хүн Линдон Бейтс Монголд ирж түүний улс төр, эдийн засгийн байдлыг нүдээр үзэж нутагтаа очоод нийтлүүлсэн «Хятадад очих Оросын зам» хэмээх номондоо Монголоор туушид нь төмөр зам байгуулбал Америкаас Азийн гүн рүү худалдаа хийх боломж нээгдэх юм гэж тэмдэглэснээс үзвэл Монголд АНУ зохих ёсоор нөлөөгөө тогтоох ёстойг анхааруулсан хэрэг ажээ.<sup>8</sup>

1910 онд Монголыг хуваасан Япон-Оросын нууц гэрээ дахин байгуулсан явдлыг Англи, АНУ-д таашааж үзээгүй. Английн Бланд хэмээгч түүхчин «Одоо үед шинэ эвсэл байгуулснаар Орос, Япон хоёр (Монголд) тайван замаар нэвтэрч статусквог нь (одоо байгаа байдлыг) аажимдаа өөрчлөн тайлбарлах замаар өөр өөрийн зорилгыг биелүүлэх зай ч байна, цаг хугацаа ч байна» хэмээн бичжээ.

Монголд XIX зууны сүүлч үеэс эхлэн олон улсын капитал их бага хэмжээгээр оролцсон «Монголор» гэдэг алт ашиглах уурхайд Америкаас ачуулсан тоноглол багаж хэрэгслийг зам зуураа дээрэмдүүлж байж Монголд авчирсан бөгөөд 40 гаруй америк инженерийг урьж ажиллуулж билээ. Энэ тухай Бадаргуулт төрийн 27 оны (1902) 2-р сарын 14-ний өдрийн нэг бичигт өгүүлсэн нь: «АНУ-д одоо зэвсэг сав 6 ижийг худалдан авч ордны багш 46 хүнийг залсан явдлыг урьд хожим мэдүүлсэн... зэвсэг саваас 2 ижийг Чуулалт хаалгын газраа муу ардад эвдүүлснээс гадна үлдсэн нь нэгэнт захын газарт хүрч ирсэн, ордны багш мөн урьд хожид хооронд хүрч ирсэн...» гэжээ.<sup>9</sup> Монголд өөрийн нөлөөг түгээхийг эрмэлзсэн АНУ эдгээр инженерүүдийг Ерөөгийн алтны уурхайд явуулж ажиллуулах сонирхолтой байсан нь гарцаагүй бөгөөд цаашдаа «Монголор»-ын уурхайг америк маягийн боловсронгуй болгохыг зорьж байв.

## **2. Буурай орны нэрийг өргөсөн нь**

Хүн анх үүссэн газар орныг, дэлхийн бөмбөрцгийн аль нэг өнцөг булангийн ямар орон болохыг газарзүйн тогтоц, үе, давхарга, цаг уурын хувьсал, өөрчлөлт, байршил зэрэг олон зүйлийн нөхцөл байдал зэргийг өнө эрт галавын үеэс нь өнөөг хүртэл явж ирсэн байдлыг улируулан маш нарийн судлаад, тийнхүү хүн анх үүссэн хамгийн боломжтой газар нь төв Азийн хойд хэсэг, Монгол нутаг гэсэн таамаглал дэвшүүлснээр манай орныг Америкийн эрдэмтдээс сонирхон судлах ажил эхэлсэн түүхтэй.

Америкийн эрдэмтэд Монгол нутаг хүн үүссэн анхны өлгий мөн болох тухай таамаглалын асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй үнэн зөвөөр тайлах нь тэдний ажлын гол сэдэв болсон бөгөөд Америк-Монголын харилцааг хөгжүүлэх гол хөшүүрэг болж өгсөн юм. Энэ тухай Америкийн эрдэмтдийн бүтээлд Монгол нутаг хүн анх үүссэн төв байж болох тухай санааг зуу гаруй жилийн тэртээ эрдэмтэд дэвшүүлж байсныг доктор Нельсон Америкийн байгалийн түүхийн музейн номын санд хадгалагдаж байсан «История Вопросы» гэдэг бүтээлээс олж танилцжээ. Энэ санааг анх Жозеф Лейди бүр 1857 онд дэвшүүлсэн юм. Түүнээс хойш А. Катржаф 1889 онд «Всеобщая история человеческих рас»

хэмээх алдарт бүтээлдээ: «Төв Азийн хойд районуудад сармагчин анх хүн болж хувьссан нэгдсэн төв байж болох юм. Тэрхүү хүй нэгдлийн үеийн бүдүүлэг хүмүүс нь эндээс манай гаригийн өмнөт халуун район руу нүүдэллэн очсон юм» гэж өгүүлжээ. Түүний дараа Америкийн нэрт эрдэмтэн, профессор Г. Осборн өөрөө төв Ази-Монголын говьд ирж үзээгүй байхдаа. Төв Азийн газар зүйн тогтоц, бүтэц, орчин нөхцөл, байгаль цаг уурын өөрчлөлт хувьсалтын талаар олон жил суурь судалгаа хийж, «Цаг уур ба хувьсал» гэдэг алдартай бүтээл туурвисан доктор В. Мэтьютай хамтран судалгаа шинжилгээ хийж, бүх тивүүдийн амьд амьтан анх Ази тивд үүсэж бий болоод тэдгээр амьтад дэлхийн бусад тивүүд рүү очихоор тал тал тийшээ тархан нүүдэлдэн явсан гэсэн онолыг 1900 онд дэвшүүлсэн билээ. Тэгээд Г. Осборн өөрийнхөө онолын үнэн зөв болохыг батлахаар 20 гаруй жилийн дараа 1918- 1925 онуудад Монголын говьд Америкийн төв Азийн экспедицийг толгойлон удирдаж ирээд 3 удаа Төв Ази-Монголын говьд ажиллахдаа олсон олдворууд-нээлт нь түүний онолын үнэн зөв болохыг баталж өгчээ.

Америкийн экспедиц ирж Монголын шаварын-Ус гэдэг газраас 100 сая жилийн өмнө буюу Цэрдийн галавын үед амьдарч байсан жижиг хөхтөн амьтны толгойн яс 5 ширхгийг доктор Гренжер анх олж, судалж үзээд тритилодон гэж нэр өгсөн байна. Эрдэмтэд уг олдворыг нарийвчлан судлаад хөхтөн амьтны хамгийн анхны өвөг амьтан мөн гэж тогтоожээ. Удалгүй Америкийн хэвлэлд профессор Ч. Андриус тэрхүү гайхамшигт олдворыг үнэлэн бичихдээ, Монгол орон дэлхийн бүх эрдэмтдийн анхаарлыг татсан шинэ нээлтийн эх үндэс болсон нь эргэлзээгүй гэж өгүүлсэн байдаг.

Профессор Г. Осборны бодлоор бол Монгол нутаг нь эртний хүний бие бялдар, оюун ухаан хөгжин хувьсахад зохицсон газар гэж үздэг байжээ. Балар эрт үеэс Ази тивийн энэ хэсэг газар нь олон сая жил далайн ус бялхаагүй, харин энд задгай огторгуйд хатуу ширүүн уур амьсгал нь хүний өвөг дээдсээс хоол хүнсээ олоход болон ер нь амьдрахын тулд маш идэвхтэй байнгын үйл ажиллагааг аяндаа шаардаж байв. Азийн халуун бүсэд биш, гагцхүү төв Азийн хойд хэсэг болох энэ нутагт л анхны хүний өвгийн ясны үлдэгдлийг эрэх хэрэгтэй гэж үзэж байсан юм. Доктор В. Д. Мэтьюгийн нотолсноор, хүн төрөлхтний тархсан төв нь Монголын нутаг дээр дандаа байгаагүй юм, түүний Монголын цаг уурын эрс тэс ширүүсэлт болон хуурайшилттай холбогдон «тархалтын төв» нь өмнө зүг болон говиос баруун зүгт түргэн шилжсэн гэж тогтоожээ.

Америкийн эрдэмтэд жинхэнэ эрдэм номын ариун цагаан буянт үйлсийн төлөө Монгол орныг сонирхон судлахдаа Монгол нутаг хүн төрөлхтөн анх үүссэн төв байж болох тухайн асуудал түүнчлэн манай гаригийн анхдагч амьтан Монголоос олдсон зэрэг олон тооны эрт галавын үеийн сонин хачин амьтад олдсон тухай ч нарийн судлан шинжилж, тэдгээр амьтдын амьдарч байсан он цагийг тогтоон тэдгээр олдворын ихэнхийг зургийн хамтаар Америкийн хэвлэлүүдэд, дэлхийд нэрд гарсан том эрдэмтэд тайлбар тодорхойлолт хийн нийтлүүлж байв. Тухайлбал, профессор Ч. Андриус, профессор Г. Ф. Осборн, доктор В. Гренжер, профессор А. В. Грабо, профессор П. Верки, доктор Ф. К. Моррис, доктор М. Аллен, доктор Р. В. Чани, доктор Н. К. Нелсон, А. В. Понд, профессор Т. Шардан, Л. Роберт, Л. М. Хилл, профессор В. Вуман нарын зэрэг хүмүүс доорхи бүтээлүүдийг туурвижээ. Үүнд: «Төв Азийг шинээр байлдан дагуулсан нь» боть I; «Монголын геологи» боть II, «Монголын геологийн судлал» боть III; «Пермийн галавын Монгол» боть IV; «Монголын хөхтөн амьтны нас» боть VII, «Монголын мөлхөгч амьтдын нас» боть VI, «Монгол ба Хятадын хөхтөн амь-

тад» боть XI, «Монголын эртний ургамал, амьтан» боть XII, «Монголын газрын зураг зүй» боть V, «Монголын археологи» боть VIII, «Америкийн төв Азийн экспедицийн Монголд хийсэн ажлын урьдчилсан тайлангийн эмхтгэл» 1-р боть (1918—1925 он), 2-р боть (1926—1929 он) зэрэг бүрэн хэмжээний эрдэм шинжилгээний 13 боть ном болон хэдэн зуун судалгааны өгүүлэл хэвлэгдсэн байна. Бас эдгээр олон бүтээлийн нэлээд олон өгүүлэл орос, франц, герман хэлээр орчуулагдах зэргээр дэлхий дахинд тархсан явдал нь тэр үеийн Азийн өчүүхэн жижиг, буурай, хоцрогдсон Монгол орны нэр алдрыг даян дэлхийд алдаршуулан өргөсөн нь Монгол орны хувьд тун чухал ач холбогдолтой зүйл болсон юм.

Америкийн эрдэмтдийн Монголд ирээд хийсэн онол, нээлтүүд нь он жил өнгөрөх бүр улам олон шинэ материалуудаар баяжин батлагдсаар байгаа нь маргаангүй үнэн. Тэр үед Монголд экспедицээр ирсэн янз бүрийн мэргэжлийн олон эрдэмтэд нь шинжлэх ухааны гүн гүнзгий үндэслэл бүхий, нээлт хийсэн дорвитой сайхан бүтээлүүд туурвисан нь хойч үеийн төв Ази-Монгол орныг судлагч орнуудын эрдэмтэн-судлаачдын судалгааны ажилд мөрдөн хэрэглэх гарын авлага болсоор байна. Америк эрдэмтдийн Монголын тухай бичсэн тэр олон бүтээлүүдээс ганц нь ч монгол хэлнээ орчуулагдаагүй өнгөрснөөс одоо хүртэл манай орны их, дээд ерөнхий боловсролын сургуулиудын сурах бичигт ч тусгагдаагүй өнгөрчээ.

Бид алтан говиосоо олдсон хосгүй ховор олдворуудаа олон түмэнд олигтойхон сурталчилж эх орныхоо нэр төрийг дэлхий дахинд цуурайтуулахад чухам юу саад болж байсан бэ? гэдэг нь бүхэнд ойлгомжтой байлаа. Хэрэв Америкийн эрдэмтдээс Монгол орны тухай бичсэн зүйлийг орчуулан сурталчлан үнэн байдлаар нь яривал улс төрийн асуудалд орж, хөрөнгөтнийг магтан талархагч, тэдний үзэл сурталд автагдсан үл бүтэх этгээд гэх мэтчилэнгээр нэрлэн, тэр бичсэн этгээдийг янз бүрээр муучлан хавчиж, наад зах нь намын эсрэг үзэлтэн болгож, ажил хөдөлмөрөөс нь зайлуулж, амьдралгүй болгож хэлмэгдэхээс болгоомжлоод Америк орон, Америкийн эрдэмтдийн бүтээлүүдийн талаар ам ангайх эрхгүй болгон хаажээ. Ийм хаалт олон жил манай оронд ноёрхож ирсэн юм.

### **3. Монголын говиор аялсан нь**

Америкийн төв Азийг судлах экспедицийнхэн Монгол оронд анх ирээд голдуу говь нутгаар аялан явахдаа эрс тэс уур амьсгал, өдрийн хэт халуун, хуурай, хүчтэй салхи, шороон шуургатай таарч, элсний нурулт, шигдэлтэнд машин нь сууж бүтэн өдөржин ухаж өнгөрүүлэх явдал цөөнгүй тохиолдож, ус ундаар тасрах, 30—40 хэмийн аагим халуун зэрэг зүйл зүйлийн саад бэрхшээлүүдийг шантралгүй их тэсвэр хатуужил, эр зоригоор даван туулж олон зүйлийг нээн олж цуглуулсан байна. Тэд нар ингэж аялахдаа манай орны чухам ямар ямар газраар явсан тухай замын тэмдэглэл, шинжлэх ухааны үндэслэлтэй газрын зураг зохиожээ. Тэр зурагт манай улсын газар нутгийн хэмжээг одоогийнхоос нэлээд томоор тун сайн нарийвчлалтайгаар гаргасан байна. Экспедицийн бүрэлдэхүүнд оролцож ирсэн эрдэмтэд нь дэлхийн олон улс орноор явж, хүний янз бүрийн амьдралыг үзэж нүд тайлсан хүмүүс байжээ. Тэд манай улсад ирж ард олны амьдралын бодит байдлыг нүдээр үзээд гадаад Монгол бол хэний ч харъяанд биш тусгаар тогтносон биеэ даасан улс юм байна шүү дээ гэдгийг сайн ойлгосон нь уул зургаас илхэн харагдана. Монголын газар нутгийг зурахдаа түүний хилийг нь зэргэлдээ хөрш орнуудаас нь мэдэгдэхүйц ялган зурсан байлаа. Монгол улсын нутаг дэвсгэрийн байршлыг тодорхойлохдоо

говьд анх үүссэн өвөг амьтад уг төвөөсөө дэлхийн бөмбөрцгийн янз бүрийн өнцөг булан руу тархан нүүдэллэж явсныг харуулсан 1900 онд нийтлэгдсэн профессор Г. Осборны зураг нь экспедицийнхэн хаагуур хаагуур явсан, юу юу олсныг зураг дээр заахад ашиглах зорилгоор энд оруулсан байх гэж үзэж байна.

Тэд Монголын говиор аялахдаа олсон эртний амьтдын ясаа савлах, ачих, тээвэрлэхээр нутгийн ардуудаас хөлслөн авсан тэмээн хөсөг нэлээн олонтой байсан. Тэмээн жингийн цувааны ажлыг Мээрэн гэдэг хүн удирдан зохион байгуулж байжээ. Энэ экспедицийн ажилд Монгол талаас Эрдэнэбатхаан газарчлах, хэлмэрчлэх, тэдний ажилд тусалж байгаа монгол хүмүүсийг ажиллуулах зэрэгт биечлэн оролцож байсан ажээ. Экспедицийнхэн монголчуудтай маш элэгсэг дотно харилцаж нутгийн хүмүүсийн санал зөвлөлгөөг сонсож байсан нь уг хайгуулын ажил сайн болох бас нэг нөхцөл байсан байх. Говь газрын зам харгуй, ус ундтай газар олох нь урьд явж үзээгүй харийн хүнд тийм амаргүй ажил байсан нь илэрхий.

Экспедицийнхний бичсэн бүтээлүүдэд Монголоос олдсон олдвороос гадна Монгол орны 1918—1936 он хүртэлх үеийн Монголын ард түмний аж амьдрал, зан заншил, хувцас хунар, гэр орны байдал, хүн амын амьжиргааны түвшин болон лам, хар, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцааны байдал, хүрээ, хийд, сүм, дуган, малчдын ахуй байдал болон байгалийн гоо үзэсгэлэн, араатан жигүүртэн, эртний хөшөө дурсгалт зүйлс зэрэг аян замд тохиолдсон янз бүрийн сонин хачин зүйлүүдийг өнгөтэй, өнгөгүй зурагтайгаар бичжээ. Дээр дурдсан бүтээлүүд нь Монгол орны өнгөрсөн үеийн түүх, соёл, урлаг, ардын зан заншил, байгаль газар зүй, эртний ургамал, амьтны үүсэл хөгжил, цаг уур зэргийг судлахад хэрэглэгдэх 70 гаруй жилийн өмнөх үеийн Монгол орны дүр төрхийг бичгээр болон гэрэл зургаар харуулсан нь туйлын үнэтэй ховор дурсгал болсон баримтууд юм.

Америк эрдэмтдийн уйгагүй их хөдөлмөрөөр манай эртний соёлын түүхэнд холбогдох ийм лут том бүтээлүүдийг туурвиж дэлхий дахинд сурталчилж ирсэн байна. Анхны нь бүтээл хэвлэгдэн гарснаас хойш монгол судлаачдаа хүлээсээр 90 гаруй жил болж байна. Одоо бас дахин хуудсанд нь салхи оруулахгүй хэдэн жил хүлээх бол гэж бодохоос сэтгэл зовниж байна. Тэдгээр бүтээлүүд нь зөвхөн нэг үеийн хүмүүсийн оюуны хэрэгцээг хангаад зогсох бүтээл биш, олон үеийн турш судлаачид, уншигчдын оюуныг тэлж, танин мэдэхүйн хүч чадлыг асар их нэмэгдүүлж өхийн хамт байнгын гарын авлага болсон маш үнэтэй ховор сурвалж бүтээл гэдгийг зориуд хэлмээр байна.

Дээрх баримтад тулгуурлан доорхи санал дэвшүүлэн сонордуулъя.

1. Америкийн эрдэмтдийн бичсэн дээрх бүтээлүүдэд тусгагдсан Монголд нээсэн олдворуудыг бодит байдлаар нь амьдруулсан шинжлэх ухааны баримтат киног Америктай хамтран бүтээх саналыг холбогдох газрууд даруй боловсруулж тавимаар байна.

2. Монголоос дэлхийн анхны эхэс төрдөг хөхтөн амьтан олсон газар дээр нь профессор Г. Ф. Осборн, Ч. Андрус, В. Гренжер нарын хөшөө юм уу хүндэтгэлийн самбар босгох.

3. Мөнхүү газар дээр нь байгалийн үзэсгэлэн музей нээж олон улсын жуулчны бааз байгуулж зуны улиралд ажиллуулах.

4. Дээр дурдсан бүтээлүүдээс заримыг монгол хэлнээ орчуулан ойрын жилд олон түмний хүртээл болгохын хамт дунд болон дээд, их сургуулиудын сурах бичигт зохих зүйлүүдээс оруулах нь зүйтэй гэж үзнэ.

1. Улсын архив, нэгдүгээр анги, 37 дугаар бүлэг, 10-р бүс
  2. Улсын архив. 1-р анги, 36-р бүлэг, 114-р бүс Пунцагноров 76-р тал
  3. «Красный архив» т. 6, (37) 1929 г. стр. 16— 17-р талд байгаа материалаас эрдэмтэн Ц. Пунцагноров авчээ. (76---77)
  4. Ц. Пунцагноров. Монголын автономит үеийн түүх. (1911-1919) УБ 1955. 77-р талд
  5. Ш. Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа (1850—1919) 1. УБ. 1971. 160-р талд
  6. Мөн тэнд И. М. Майский Современная Монголия. Иркутск 1921 с. 206
  7. Мөн ном 260 тал, «Вестник Азии» Харбин 1912 № 11, 12. 75—76-р талд
  8. Мөн тэнд
  9. Мөн ном 156-р талд
- «The New Conquest of Central Asia» By. P. C. Andrews. Vol. I.  
«The Geology of Mongolia». By C. P. Berkey and R. K. Morris, Vol. II,  
«Geologic Studies in Mongolia». By C. P. Berkey, F. K. Morris, L. E. Spock and P. Teilhard de Chardin. Vol. III. «The Permian of Mongolia». By A. W. Grabau, Vol. IV. «The Topography of Mongolia», By C. P. Berkey, W. P. T. Hill, and Willard Wyman. Vol. V.  
«The Age of Reptiles in Mongolia». Vol. VI.  
By. H. F. Osborn and W. Granger, «The Age of Mammals in Mongolia». Vol. VII.  
By H.F. Osborn and W. Granger. «The Archaeology of Mongolia»,  
By N. C. Nelson and A. W. Pond. Vol. VIII, «The Mammals of Mongolia and Chiria».  
By Glover M. Allen. Vol. XI. «The Botany and Palaeobotany of Mongolia». By. R. W. Chaney. Vol. XII.